

Living the LOTUS

Buddhism in Everyday Life



Үүсгэн байгуулагчийн сургаал

Хамтрагчтай болох арга

Худалдаа наймаа хийх үед ч гэсэн явал зарагдах бол гэх биш, үргэлж худалдан авагчийн сэтгэлийг боддог болох юм бол амжилтанд хүрэх нь гарцаагүй. Хүнтэй харилцах ур чадвар ч гэсэн адилхан. Гэтэл хүмүүс эхэндээ өөрийгөө зөвтгөж, хүнд хүчээр тулгачихаад байдаг. Санасандаа хүрэхгүй л бол сэтгэл амрахгүй. Үүнийг дур зоргоороо аашлах гэнэ. Хичнээн ингэж хүчиллээ гээд аливаа зүйл санаснаар болохгүй.

Тийм болохоор миний хувьд эхлээд нөгөө хүнийхээ санаа бодлыг хүлээгээд авчихдаг юм. Дараа нь түүнд нь өөрийгөө яаж тааруулж, эвтэйхэн зохицох вэ гэдгийг боддог. Тэгэхлээр

ямар ч хүн санаа зовох зүйлгүй хамаг чадлаа дайчилдаг.

Хичнээн өөрийн санаснаар болсон ч гэлээ нэг хүний хүчээр хийж чадах зүйл гэдэг хязгаартай байдаг. Тиймээс сэтгэл нэгдэн хамтран зүтгэх хүн хэр олныг цуглуулах вэ гэдэг хамгийн чухал. “Бүх хүмүүс бодисадвагийн үйлийг хийж байна” гэсэн хүндлэх сэтгэлтэй болох юм бол өөрийгөө зөвтгөөд байх шаардлага огтхон гарахгүй. Бусдын санаа бодлыг хүлээн авъя, өөрийгөө тааруулъя гэсэн сэтгэлтэй байх юм бол нөгөө хүн ч гэсэн буулт хийх нь гарцаагүй. Үг хэлэхгүй байсан ч гэсэн сэтгэл гэдэг хүрдэг зүйл юм.

Living the Lotus Vol. 155 (2018.08)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Саитоо Кооичироо

Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Б. Мөнхцэцэг


Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдрал)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туульцаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Хүндлэх ба ичих сэтгэл

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Бурхан багшийн зөвлөгөө

Энэ сар “Хутагтын найман мөр” сургаалын “Зөв үйл”-ийн талаар тунгаан бодож үзэцгээе. “Зөв үйл” гэдгийг буддын шашны толь бичигт “зөв ажил үйл” гэж тэмдэглэсэн байх ба “бие, хэл, сэтгэлээр үйлдэх гурван үйл”-ийн “биеэр үйлдэх үйл”-ийг зөв хийхийг хэлдэг байна. Нэмэж хэлэхэд тус сэтгүүлийн 6, 7-р сарын дугаарт гарсан “зөв үзэл”, “зөв үг” ч гэсэн дээрх гурван үйлийн нэг болох сэтгэлээр болон хэлээр үйлдэх үйлийг зөв хэрэгжүүлэхийг хэлнэ.

Тэгвэл биеэр үйлдэх зөв үйл гэж юу юм бол? Тайлбар номонд амь хөнөөхгүй байх, худал хэлэхгүй байх, гэр бүлээс гадуурх харилцаа үүсгэхгүй байх гурвыг биеэр үйлдэх зөв үйл гэсэн байна.

Даммапада (Dhammapada) сударт “Бүх хүмүүс балмад хэрцгий явдлаас дагжин чичирч, бүх хүмүүс үхэхээс айдаг. Үүнийг өөр дээрээ тусган бодож, амь хөнөөж болохгүй. Мөн амь хөнөөлгөж болохгүй.” (Накамүра Гэнгийн орчуулга/ Иванами номын архив) гэсэн байдаг. Энэ нь өөрөө амь насаа алдаж, юмаа хулгайд алдан, ёс бус харилцааны улмаас зовж байна гээд бодоод үзэхээр яавч таатай санагдахгүй. Тиймээс хүнд ч гэсэн тийм зүйлүүдийг хийж болохгүй гэсэн үг юм.

Шагжамүни будда амьдралын зовлонгоос ангижирах арга ухааныг гэгээрсэн ба зовлонгийн шалтгаан юу болохыг бүрэн ойлгосны үндсэн дээр түүнийгээ айлдсан. Тэр утгаараа дээрх сударт айлдсан үгийг сахил гэхээсээ илүү өдөр бүрийг өөдрөг, гэгээлэг өнгөрүүлэх захиас гэж хүлээн авах нь зөв болов уу. Өөрөөр хэлбэл “Үүнийг мартажгүй байх юм бол гэр бүл ч гэсэн, нийгэм ч гэсэн энх тайван болж, сайхан амьдрах юм шүү” гэсэн Шагжамүни бурхан багшийн халуун сэтгэлийн зөвөлгөө гэсэн үг юм.

“Зөв үйл” бол мэдээжийн зүйл

“Амь хөнөөхгүй байх”, “хулгай хийхгүй байх”, “гэр бүлээс гадуурх харилцаа үүсгэхгүй байх” нь мэдээжийн хэрэг зөв үйл бөгөөд амь хөнөөх, хулгай хийхийг хуулиар хүртэл хориглосон байдаг. “Ийнхүү “хийж болохгүй” гэсэн зүйлсийг өөрөөр “зөв үйл” гэдэг гэхээр сэтгэлзүйн хувьд хийхэд хэцүү зүйл мэт санагдаж магадгүй. Тэгвэл “сахиж мөрдөхгүй бол болохгүй” гэж хэцүүгээр бодохоосоо улдаар үргэлж зүгээр л “зовлон бэрхшээл авчрахгүй байх үйл /зөв үйл/-ийг л хийдэг” болчихвол болох юм.

Ийм болоход чухал зүйл бол хүндлэх сэтгэл ба ичих сэтгэл юм.

Бид бурханы шавь учраас Бурхан багшийг хүндэлж, “Бурхан багш шиг болох юмсан” хэмээн хүсэж, бурханы үйлд хичээдэг. Үүнийхээ хажуугаар хааяа дутагдалтай талаа олж анзаардаг.

Энэ талаар күнз судлаач эрдэмтэн, сэтгэгч Ясүока Масахиро гуай “Хүндлэх хэмээх сэтгэл бол жоохон ч гэсэн эрхэм дээд түвшинд хүрье, агуу зүйлд ойртож очье гэсэн сэтгэл юм. Түүнчлэн өөртөө дүгнэлт хийж, дутагдалтай талаасаа ичих сэтгэл юм” («Ясүока Масахиро, Нэг өдөр, нэг үг» /Чичи хэвлэлийн газар) хэмээн бичсэн байдаг. Бидний хувьд чухал зүйл бол энэ үгний үргэлжлэл хэсэг юм.

“Өөрийгөө эргэн харж, өөрөөсөө санаа зовж, өөрийгөө хянаж, өөрийгөө хориглох хэрэгтэй.” Энэ нь ямар нэг агуу зүйлийг хүндлэх сэтгэлийн улмаас өөрөөсөө ичих сэтгэл төрсөн бол аяндаа дутагдалтай талаасаа болгоомжилж, бурханы сургаалын дагуу үйл хийхийг хичээдэг болно гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл “Бурхан ба бурханы сургаалыг хүндлэн дээдэлснээр зөв үйлийг мэдээжийн зүйл мэт хийдэг хүн болно” гэж ойлгож болно.

Мөн хүндлэх сэтгэл ба ичих сэтгэл нь урагш ахья, өсөн дэвшье гэсэн сэтгэлийн илрэл гэж ч хэлдэг. Тэгэхээр энэ хоёр сэтгэл нь хувиа бодсон сэтгэлд автаж, зам мөрөөс хазайчих гээд байдаг биднийг хүн шиг амьдрах угийн зам мөрт эргүүлэн оруулдаг гэж хэлж болно.

Эндээс “зөв үйл” гэдэг нь “хүндлэх ба ичих” сэтгэлээс үүсдэг гэж хэлж болохоор байгаа ба тэр сэтгэл ба үйл нь өдөр тутмын хүмүүс хоорондын харилцаанаас авахуулаад улс оронд хүртэл энх тайвныг авчрах чухал зүйл юм. Мөн эдгээр нь бурханы зам мөрөөс хазайх гээд байгаа олон тохиолдолд яг одоо чухал хэрэгтэй зүйл юм.

“Косей” сэтгүүл 8-р сарын дугаараас





Зөвөөр, байгаагаар нь хүлээн авснаар хүртэх баяр баясгалан

Батаагийн Ариунаа
РКК. Улаанбаатар салбар

Энэхүү илтгэл 2018 оны 4 дугаар сар 15нд Улаанбаатар салбарт зохион байгуулагдсан амин өдрийн үйл ажиллагаан дээр тавигдсан болно.

Бурхан багшийн амин өдөр хэмээх билигт сайн өдөр илтгэл тавих үүрэг хүлээн авсандаа баяртай байна. Миний нэр Батаа овогтой Ариунаа. 1966 онд төрсөн. Хоёр охинтой. Хоолны технологич инженер, мөн нягтлан бодогч мэргэжилтэй. Тэргүүн Зоригмаагийн урилгаар анх 2005 онд нийгэмлэгтэй танилцаж, амин өдөр болон зохион байгуулагдаж байгаа бусад үйл ажиллагаанд оролцсон боловч тэр дороо гишүүнээр элсээгүй. Яагаад гэвэл би өмнө нь бурханы сургаалыг мэддэггүй, бурхан байдагт итгэдэггүй, шашингүй үзэлтэй нэгэн байсан. Залуу байхдаа бурхан байдаггүй гэж Гандан хийдийн ламтай маргаж, философийн талаар цэц булаалдаж байснаа бодохоор одоо өөрөөсөө ичдэг. Тэр үед их сургуулиа төгсөхдөө философийн улсын шалгалтаа онц дүнтэй хамгаалсан болохоор өөрийгөө юм мэддэг, том

хүн болсон гэж буруу бодож байжээ.

РКК нийгэмлэгийн номын уншлага болон бусад үйл ажиллагаанд оролцох явцад нийгэмлэгийн сургаал, бурханы сургаалтай аажим аажмаар танилцаж, “хүний төлөө”, “сайн хүн өсгөж хүмүүжүүлэхийн төлөө”, бүх хүмүүсийн аз жаргалтай амьдралын төлөө” гэсэн РКК-н үндсэн үзэл баримтлал надад маш их таалагдсан. Мөн Монголын РКК нийгэмлэгийн гишүүд, хамт олны халуун дотно, бие биенээ хүндэтгэсэн харилцаа, хооза хийх зэрэгт татагдаж байв. Тэр үед долоо хоног бүрийн бямба гарагт цугладаг байсан ба дараа долоо хоногийн цугралтыг тэсэн ядан хүлээдэг болсон байв. Ийнхүү 2009 онд гишүүнээр элссэн.

Элсээд удалгүй сургалтын албанд хуваарилагдсан. Тухайн үед бурханы сургаалыг сайн мэдэхгүй хэмээн татгалзсан боловч Зоригмаа тэргүүний зааж зөвлөснөөр “суралцсан хойноо хэрэгжүүлэх” биш “суралцангаа хэрэгжүүлэх” сургаалын дагуу гишүүдтэй хамтран ажиллаж, төв болон орон нутагт сургаал түгээх, дэг жаягийг заах ажилд биечлэн оролцож, Японы сувилахуйн сургуульд оюутан элсүүлэх, гэрээ байгуулахад хамтран ажилласан. Мөн санхүүч, БГД-ийн ахлагч, сургалтын менежерийн үүргийг гүйцэтгэж байсан.

2011-12 онд Японы төвд зохион байгуулагддаг “Лидерийн сургалт” хамрагдаж, гадаадын олон бодисадва нартай найз нөхөд болсон. Тэдний юм болгоныг бурханы сургаалтай холбож чадаж байгаа нь үнэхээр гайхалтай байсан ба тэр арга барилаас суралцмаар санагдсан.

2017 оны 10 сард номын багшийн эрхийг хүлээн авснаас хойш, сахилын нэрний захиалга авах, залах тусгай зориулалтын ном унших үүргийг хүлээн авсан.



Гишүүн Б.Ариунаа Улаанбаатар салбарын өргөөнд илтгэл тавьж байгаа нь

Хамгийн сүүлд 5 сард Эрдэнэт хэсэгт бурхан залах ажлын багт орж, үүрэг хүлээн авсан. Энэ үүргээр дамжуулж өөрийгөө улам танин мэдэж, бурханы сургаалыг шамдан суралцахад тус дөхөм болж байна.

7 сарын 1 нд Эрдэнэтийн хэсэгт Ариун ордноос хүлээн авсан Бурханы дүрийг залах завшаан тохиогоод байгаа билээ. Эрдэнэт хэсэгт бурхан залах ажилтай холбогдуулан тэргүүн, санхүүч, Зоригт нарын хамт 5 сарын 8-9нд Эрдэнэт рүү явж, ахлагч болон гишүүдтэй уулзаж санал бодлоо солилцсон. Биднийг ороход ахлагч суудлаасаа босож мэндлэлгүй, судраа уншихгүй өөр зүйлд анхаарч байгаа нь эхэндээ таагүй санагдав. Судар уншлагын дараа ахлагчаас ирж буй гишүүдийн тоо, хандивын орлого, хэрхэн сургаалаа түгээж, өглөг цуглуулах тухай асуухад ихэд дүргүйцэж, яриаг таслан “бид сургаалаа сайн уншиж байгаа, бид мэднэ, биднийг магтахгүй байна, харин Хиросэ дарга биднийг магтаж байгаа” зэргээр ярьсан нь тухайн үед эвгүй санагдсан. Гэвч “асуудлыг байгаагаар нь хүлээн авах, зөв өнцөгөөс хүлээн авах” сургаалыг санаж, тэднийг мөнгө санхүүдээ санаа зовоод ингэж байгаа болов уу гэж бодов. Мөн сайтар ажиглахад судраа идэвхтэй уншдаг ахлагч тэр өдөр ачыгаа дагуулан ирсэн байсан тул судар уншлагад оролцож чадаагүй гэдгийг анзаарав. Ийнхүү асуудлыг байгаагаар нь харахад ахлагчийн хичээл зүтгэл нүдэнд тодорхой харагдаж, бурханлаг чанарт нь залбиран мөргөж чадсан юм.

Мөн дээрхтэй төстэй байдал 2018 оны 3 сарын 31 нд Хөвсгөлийн хэсэгт очиход ажиглагдсан. Хөвсгөл салбарын ахлагчтай өмнө нь уулзаж байгаагүй тул ямар хүн байгаа бол доо гэж бодсоор очсон. Үнэндээ энэ удаагийн томилолт чухал шалтгаантай байв. Хөвсгөлийн ахлагч Зоригмаа тэргүүнд намрын баярт орох хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ. Гэвч тухайн үед ахлагч хүндээр өвдсөн байсан тул Зоригмаа тэргүүн эрүүл мэндэд нь санаа зовж, “энэ жил дэмий байхаа” хэмээн хариулсан нь Хөвсгөлийн ахлагчид хүндээр туссан байжээ. Удалгүй ахлагчаас “хэсгийн ахлагчийн үүргийг буцаан өгмөөр байна, үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй” гэсэн утас ирсэн байв. Ингээд Зоригмаа тэргүүнээс сургаал түгээлтээр явахын

өмнө “Хөвсгөлийн ахлагчийн биеийн байдал, байр байдлыг сайн ажиглаарай” гэсэн даалгавар авсан байв.

Хөвсгөлийн хэсэгт очиход ахлагч нь мөн л суудалдаа суусан чигтээ мэндлэв. Миний хүмүүжлээр бол холоос ирсэн зочинг хүндэтгэж, босож мэндлэх нь ёстой байтал суусан чигтээ байсан тул эхэндээ тун гайхав.

Гэвч би Хөвсгөлийн ахлагчийн сайн талыг олж харан, магтахыг хичээв. Ахлагч өвчтэй байгаа болохоор хүнтэй босож мэндэлж чадахгүй байгаа юм байна гэж бодоод, тэдний хэсгийн 8 хүний нэр дээр эрүүл мэндийн ном уншиж өгсөн. Тэгтэл Хөвсгөлийн ахлагчийн байр байдал мэдэгдэхүйц зөөлөрч ирэв. Улаанбаатар луу харьсны дараа ахлагч, Зоригмаа тэргүүн лүү ярьж, үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэнэ гэж хэлсэн байлаа. Түүнийг сонсоод би маш их баярласан.

Хэрвээ би сургаал сонсож байгаагүй бол дээрх шиг өөр өнцөгөөс харж, хэрэгжүүлж чадахгүй байсан болов уу. Энэ бүхэн “өнөөдрөөрөө амьдрах”, “байгаагаар нь хүлээж авах”, “зөв өнцөг, зөв үзлээр харах” сургаалыг уншиж судалсны үр дүн гэж бодож байна.

Өнгөрсөн жил номын багшийн эрхийг авахын өмнө сахилын нэрний талаар заалгасан. Өмнө нь Зоригмаа тэргүүн бурхан болсон ээждээ сахилын нэр бүтээлгэж, номыг нь уншвал яасан юм бэ гэж хэд хэдэн удаа санал болгосон боловч би “дараа больё” гээд авах гэж яардаггүй байлаа. Гэвч номын багшийн эрх авахын өмнөх сургалтаар сахилын нэрний тухай сайн ойлгосон тул ээждээ бүтээлгэж, номыг нь уншиж байгаа.

Одоо би Улаанбаатар салбарт сахилын нэрний захиалга авах, мөн залах тусгай зориулалтын номыг унших үүргийг гүйцэтгэж байгаа. Өмнө нь ажлаа урьд нь тавиад үүргээ зай завсраар нь гүйцэтгэдэг байсан болодоо сахилын нэр бүтээлгэе гэсэн хүн байвал ажлаасаа урьд тавьж, аль болох хурдан бүтээгээд өгөх юмсан, номыг нь уншаад өгөх юмсан гэж боддог болсон.

Дараа нь ном уншуулаад, сахилын нэрээ залуулаад сайхан болсон гэсэн мэдээ гишүүдээс ирэхээр их сайхан санагддаг.

Өнгөрсөн жил сахилын нэрний захиалга

Spiritual Journey

өгсөн байсан Эрдэнэт хэсгийн нэгэн гишүүнд янз бүрийн шалтгааны улмаас хүлээлгэж өгөж амжихгүй явсан юм. 5-р сард Эрдэнэтэд очихдоо сахилын нэрийг гардуулан, залах номыг нь уншиж өгөөд, урьд нь очиж бүтээж өгөөгүйдээ уучлал гуйгаад, тэдний өвөг дээдэс болон тус гишүүнд талархалаа илэрхийлсэн. Энэ үед эхэлсэн ажлаа дуусгаад мөн тухайн гишүүнээс талархал сонсоод сэтгэл хөнгөрөөд сайхан байсан. Тэр гишүүн маань сахилын нэр бүтээлгэсэндээ талархаж, амин өдрийн уншлагаа үргэлжлүүлж байгаа гэсэн.

Анх гишүүн элсэж байх үедээ би бурханы сургаалаас мэдэхгүй, баярлаж талархсанаа ч ил тод илэрхийлж чаддаггүй, дотогшоогоо, ганцаардмал зантай байсан. Мөн туслалцаа хэрэгтэй байгаа хүнийг хараад тусламаар байсан ч санаа зовоод хөдөлж чаддаггүй байсан.

Ирэх онд гишүүнээр элсээд 10 жил болно. Энэ хугацаанд сургаалаас суралцаж, хоозад олон суусны ачаар илүү нээлттэй болж, өөрийн бодсон зүйл, талархалаа чөлөөтэй илэрхийлдэг болсон. Жишээ нь автобусанд явж байхад мөнгө нь хүрэхгүй сандарч байгаа хүн байвал дутаад байгаа мөнгийг нь гаргаад өгөх ч юм уу туслалцаа хэрэгтэй хүнд туслаж чаддаг болсон. Одоо бол сургаалын үнэн зөвийг ойлгон мэдсэн учраас нэг ч гэсэн хүнд сургаалыг түгээж, аз жаргалд хөтлөн оруулах чин хүсэлтэйгээр суралцангаа хэрэгжүүлж явна.

Би 5н гишүүн элсүүлсэн. Тэд нар маань ажил, сургуультай учир нийгэмлэгтээ хааяа ирдэг.




Гишүүн Б.Ариунаа ном голлон уншиж байгаа нь

Урьсан хүмүүс маань гишүүнээр элсэхдээ хойрго байдаг нь би өөрөө их удаж байж элссэнтэй холбоотой болов уу. Тэднийг байгаагаар нь хүлээн авч, цаг нь болохоор элсэнэ биз дээ гэж боддог.

Эрдэнэтээс ирээд тэдний хэсэгт хандив, сэтгэлийн өглөгийг цуглуулах ажлыг санаачлан тусгай хайрцагт хандив цуглуулж байгаа. Мөн Эрдэнэтийн бурхан залахаар явсан хоёр гишүүний хамт 1 өдрийн номын уншлага, сургалтыг зохион байгуулсан. Эрдэнэт хэсгийн ахлагчийн хичээл зүтгэлийг үнэлж, хойшид ч гэсэн дэмжих болно.

Сургаалыг амьдралдаа хэрэгжүүлснээрсэтгэл амар амгалан болж, талархажөөдрөг сайхан байгаа бөгөөд шинэд суралцаж, хуучнаа амьдралдаа алхам алхамаар хэрэгжүүлж байгаа. Энэ бүх өөрчлөлтийн эхлэлийг зааж, нийгэмлэгт хөтлөн оруулсан Зоригмаа тэргүүндээ баярлалаа. Түүнчлэн намайг үргэлж дэмжиж, тусладаг номын андууддаа талархал илэрхийлье.



Living the
 **LOTUS**

Хязгааргүй утгын тухай судар

Ном номлохуйг үгүүлэх 2-р бүлэг

Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар



Их чимэглэлт бодисадва Бурхан багшаас “Бодисадва бид нар тойруу замаар явалгүй, бурханы түвшинд шууд хүрэхийн тулд ямар үйл хийвэл зохилтой вэ” хэмээн асууна. Бурхан багш ийнхүү хариулна.

Чанар, дүр, хоосон, амгалан

“Хязгааргүй утга хэмээх сургаал л та нарыг дээдийн гэгээрэлд хүргэнэ. Энэ нь ямар сургаал вэ гэвэл эхлээд дараах зүйлийг сайтар ойлгох хэрэгтэй.”

“Ертөнцийн бүх юмс үзэгдэл эрх тэгш ба үргэлж нэгэн агуу тэнцвэрийг хадгалж байдаг” гэсэн ойлголт юм. Хүмүүс бидний нүдэнд аливаа зүйлс том ба жижиг, үүсэх ба устах, зогсох ба хөдлөх гэх зэрэг ялгаатай бөгөөд янз бүрээр өөрчлөгдөн хувирч байгаа мэт харагддаг. Гэвч угтаа бүх юмс үзэгдэл ямар ч үед хоосон чанартай байдаг ба цорын ганц жинхэнэ үнэн (Дарма)-аас үүсэлтэй гэдгийг ухаарах хэрэгтэй.”

Энэ нь “Бүх юмс үзэгдлийн чанар, дүр нь хоосон бөгөөд амгалан” гэсэн сургаал юм. “Чанар” гэдэг нь аливаа зүйлийн чанар, “дүр” гэдэг нь чанарын ил харагдах дүр төрхийг хэлнэ.

“Хоосон” гэдэг нь бүх юмс үзэгдэл шүтэн барилдлагын хуулийн дагуу оршдог бөгөөд ямар нэг тодорхой зүйл бусдаас хамааралгүй оршиж, бүх юмсын эх үндэс болдог гэсэн юм огт байхгүй гэсэн үг. Тийм болохоор бүх юмс үзэгдэл угтаа эрх тэгш гэсэн үг юм. “Амгалан” гэдэг нь “агуу зохилдлогоотой байх” гэсэн утгатай. Бүх юмс үзэгдэл гялалзан өсөж хөгжингөө өөр хоорондоо шүтэн барилдаж, хамгийн тохиромжтой байдалд байдаг гэсэн үг юм.

Шагжамүни будда мөн ийнхүү айлдана.

“Гэвч ихэнх хүмүүс энэхүү жинхэнэ үнэний хуулийг мэдэхгүйн улмаас өнгөн талын бодит байдлыг л харж, энэ ашигтай, энэ ашиггүй гэх

мэтчилэн өөрийн дураар дүгнэж, муу сэтгэлийг үүсгэн, буруу үйл хийснээр үргэлж зовлон бэрхшээлтэй тулгарч, хичнээн хугацаа өнгөрлөө ч тэр буруу амьдралаасаа ангижирч чаддаггүй.

Бодисадва нар та бүгд үүнийг сайтар ухаарч, хамаг амьтныг энэрэн нигүүлсэх сэтгэлийг үүсгэж, хүмүүсийг зовлонгоос бүрэн ангижируулахын төлөө сэтгэл шулуудах хэрэгтэй. Үүний тулд хамаг юмс үзэгдлийн жинхэнэ дүр төрхийг ялгаж салган харах үйлийг улам гүнзгий хийх чухал болно.”

Шагжамүни будда ийнхүү амьдралын зовлонгийн үндсэн шалтгааныг хэлж өгч, бодисадва нар хүмүүсийг зовлонгоос ангижируулахын тулд юу хамгийн чухал болохыг заан сургана. Дараа нь аливаа зүйлсийн өнгөн талын ялгаатай дүр, түүний өөрчлөн хувирах явцыг ч гэсэн сайтар ажиглах хэрэгтэй хэмээн сургаж ийнхүү айлдана.



Хязгааргүй утга ганц хуулиас үүсдэг

“Олон хүмүүсийн ойлгох чадвар, зан чанар, хүсэл шунал ямар болохыг сайтар ажиглах хэрэгтэй. Хүмүүсийн ойлгох чадвар, зан чанар, хүсэл шунал өөр өөр байдаг тул айлдах сургаал нь ч гэсэн мэдээж хэрэг өөр өөр байна.

Гэхдээ тэр хязгааргүй олон сургаал нь угтаа ганцхан жинхэнэ үнэний хууль (дарма)-аас

үүссэн байх ёстой. Тэр цорын ганц жинхэнэ үнэний хууль гэдэг нь дүр төрхгүй ба дүр төрхгүй тул бусдаас ялгарах зүйл огт үгүй, ялгаа үүсгэдэггүй ба үүнийг жинхэнэ дүр төрх гэнэ.”

Энд буддизмын «жинхэнэ дүр төрх» гэсэн ойлголтын талаар тодорхой айлдсан байна. Жинхэнэ дүр төрх гэхээр үгнийх нь дагуу

өнгөцхөн ойлгодог боловч хамаг юмсын «жинхэнэ дүр төрх» гэдэг нь ийм гүн гүнзгий утгатай болохыг тогтоож авах хэрэгтэй. Ийм гүн гүнзгий утгатай тул энгийн хүний хувьд үүнийг бүрэн гүйцэд ойлгож чадахгүй юм.

Их чимэглэлт бодисадва дахин ийнхүү асууна.

“Ялж төгс нөгчсөн та хязгааргүй утгын сургаалыг дахин тайлбарлаж өглөө. Энэ нь өмнөх сургаалуудтай үндсэндээ адилхан гэж бодож байна. Гэвч өмнөх сургаалуудаас юугаараа ялгаатайн учир энэ хязгааргүй утгын сургаалыг л ойлгочих юм бол дээргүй гэгээрэлд шууд хүрч чадна хэмээн айлдана вэ?”

Шагжамүни будда ийнхүү хариулна.



40 гаруй жил жинхэнэ үнэнийг айлдаагүй

“Би бодь модны дор бурханы гэгээрлийг олж, ертөнцийн хамаг юмсыг ажиглан хараад одоогийн хүмүүсийн түвшинд гэгээрсэн зүйлээ тэр чигээр нь айлдах нь эсрэгээр сайн үр дүнд хүрэхгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн юм. Тиймээс хүмүүсийн нөхцөл байдал, ойлгох чадвар, зан чанар, хүсэл шуналд тааруулан сургаал айлдаж, өөр өөр аргаар аварч, зам мөрд хөтлөн оруулж байсан билээ.

Тийнхүү хүмүүсийн түвшинд тааруулж сургаал айлдаж ирсэн тул жинхэнэ үнэнийг бүрэн гүйцэд тайлбарлах боломж гарахгүй байсаар өнгөрсөн 40 жилийн хугацаанд жинхэнэ үнэний хуулийг айлдаж чадаагүй билээ.

Миний өнөөг хүртэл айлдаж ирсэн сургаалууд бүгд ганцхан жинхэнэ үнэний хуулиас үүсэлтэй. Гэхдээ жишээлбэл ямар ч ус байсан ус гэдгээрээ адилхан боловч уулын амаар урсах ус, усны шуудууны ус, цөөрмийн ус, уудам далайн ус өөр өөр байдаг шиг миний айлдсан сургаалын эхэн үеийн сургаал, дунд үеийн сургаал нь одоо айлдах сургаалтай яг адилхан гэж хэлж чадахгүй. Үг хэллэг нь адилхан мэт боловч агуулгын хувьд ялгаатай юм.

Хамаг бурхад ганцхан жинхэнэ үнэний хуулийг л айлдсан. Хүмүүс өөр өөрийн шалтгаанаар тэр ганцхан хуулийг эрэлхийлдэг тул тухайн хүнд таарсан олон янзын аргаар айлддаг. Түүнчлэн Бурханы жинхэнэ амь бие ч гэсэн цорын ганц байдаг боловч хязгааргүй олон янзаар ил гарч ирж, тэр болгон нь хязгааргүй олон янзын үйлчлэл үзүүлдэг. Энэ бол Бурхан гэдэг зүйлийн гайхамшигт ертөнц юм. Нирваан бологсод хийгээд брадэбуда түвшний хүмүүс төдийгүй бурханы гэгээрэлд тун ойртсон бодисадва нар

хүртэл тэр ертөнцийг жинхэнэ утгаар нь ойлгож чадахгүй. Энэ нь бурханы гэгээрэлд хүрч байж л хүрдэг түвшин ба Бурхан л үүнийг бүрэн ойлгож чадна. Энэхүү бурханы гэгээрэлд хүрэхийн тулд саяны айлдсан хязгааргүй утга гэдэг зүйлийг гүн гүнзгий ухаарч, өөрийн болгох хэрэгтэй.”

“Бүх юмс үзэгдлийн чанар, дүр нь хоосон, амгалан бөгөөд ганцхан хуулиас үүсэлтэй” гэдгийг хар ухаан бодоод үзвэл ерөнхийдөө ойлгогдож байна. Гэвч энэ нь зөвхөн ерөнхийд нь ойлгосоноос цаашгүй ба сэтгэлийнхээ гүнээс бүрэн төгс ойлгосон хүн байхгүй. Үүнийг бүрэн ойлгоно гэвэл Бурхантай адил билиг оюунтай болох шаардлагатай. Хэрэв бүрэн ойлгож чадах юм бол бурханы гэгээрэлд хүрсэн гэсэн үг болно. Иймийн тул Бурхан багш «Цагаан лянхуа судар»-ын «Уран арга 2-р бүлэг»-т “Тагцхүү Ялж төгс нөгчсөн бээр мөн чанарын билигийг төгс мэдэж чадмой” гэж айлдсан учиртай.

Тэглээ гээд бид сэтгэлээр унаж болохгүй. Бурхан багшийн шавь нар дотор билиг оюунаараа 1-рт ордог Шаарийбуу хүртэл энэ «Хязгааргүй утгын тухай судар»-ын сургаалыг сонсоод гэгээрэлд хүрч чадаагүй. Тиймээс Шагжамүни будда дараа нь «Цагаан лянхуа судар»-ыг үргэлжлүүлэн тэвчээртэй айлдаж, хамаг амьтныг гэгээрэл рүү хөтлөн дагуулсан юм. Тиймээс энэ «Хязгааргүй утгын тухай судар»-ыг уншаад огт ойлгохгүй байсан ч хамаагүй. Бүх юмс үзэгдлийн “жинхэнэ дүр төрх” гэдэг зүйлийн тухай бүдэг бадаг ч гэсэн толгойдоо хийгээд авахад л хангалттай.

Нивано Никкёо “Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар /шинэ хэвлэл/”, Косей хэвлэлийн компани,

2016, X16 -21



“Зөв үйл” бол энх тайвныг бий болгох чухал зүйл

8-р сар болохоор “дайн”, “энх тайван” гэсэн хоёр үг санаанд ордог юм.


Хиросима, Нагасаки нийгэмлэгүүдэд жил бүр “Атомын бөмбөг дэлбэрсэн өдөр”-ийн номын хурал болдог ба өөд болсон олон хүмүүсийн сүнс амар амгалан болж, дэлхийн энх тайван болоосой хэмээн чин сэтгэлээсээ залбирал үйлддэг. “Амар амгалан нойрсогтун. Бид дахин ийм алдаа гаргахгүй” гэж.

Шашны байгууллагын энх тайвны үйл ажиллагааны хувьд “Дэлхийн энх тайвны төлөөх залбирал” 1986 онд Италийн Ассизи хотод зохион байгуулагдсан ба энэхүү үзэл санааг уламжлан авсан “Хиэзан шашны олон улсын чуулган” одоо ч гэсэн 8-р сард хуралддаг.

Ерөнхийлөгч энэ сарын сургаалдаа “зөв үйл” гэдэг нь “«хүндлэх ба ичих» сэтгэлээс үүсдэг ба тэр сэтгэл ба үйл нь өдөр тутмын хүмүүс хоорондын харилцаа төдийгүй улс оронд хүртэл энх тайвныг бий болгох чухал зүйл юм” хэмээн айлдсан.

Тиймээс бид өдөр тутамдаа зөв үйл хийж энх тайвны төлөө нэг алхам урагшилах хэрэгтэй.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Коичи



We welcome comments on our e-newsletter Living the Lotus. Please send us your comments to the following e-mail address.
E-mail: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2018

Rissho Kosei-kai International

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Sugunami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 *Fax:* 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street Suite #1 Los Angeles CA 90033 U.S.A.
Tel: 1-323-262-4430 *Fax:* 1-323-262-4437
e-mail: info@rkina.org <http://www.rkina.org>

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way,
WA 98003 U.S.A.
Tel: 1-253-945-0024 *Fax:* 1-253-945-0261
e-mail: rkseattlewashington@gmail.com
<http://buddhistlearningcenter.org/>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
P.O. Box 692148, San Antonio, TX78269, USA
Tel: 1-210-561-7991 *Fax:* 1-210-696-7745
e-mail: dharmasanantonio@gmail.com
<http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.
Tel: (727) 560-2927 *e-mail:* rktampabay@yahoo.com
<http://www.buddhismtampabay.org/>

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 *Fax:* 1-808-455-4633
e-mail: info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 *Fax:* 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona,
HI 96740 U.S.A.
Tel: 1-808-325-0015 *Fax:* 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 *Fax:* 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rkina.org/losangeles.html>

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado
Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego
Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas
Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951
e-mail: info@rksf.org <http://www.rksf.org>

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016 U.S.A.
Tel: 1-212-867-5677 *Fax:* 1-212-697-6499
e-mail: rkny39@gmail.com <http://rk-ny.org/>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056 U.S.A.
Tel: 1-773-842-5654 *e-mail:* murakami4838@aol.com
<http://home.earthlink.net/~rkchi/>

Rissho Kosei-kai of Fort Myers

<http://www.rkftmyersbuddhism.org/>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112 U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: rkokdc@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204 U.S.A.
Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419 U.S.A.
<http://www.rkina-dayton.com/>

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060 Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377
Fax: 55-11-5549-4304
e-mail: risho@terra.com.br <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000 Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District,
Taipei City 100 Taiwan
Tel: 886-2-2381-1632 *Fax:* 886-2-2331-3433
<http://kosei-kai.blogspot.com/>

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District,
Tainan City 701 Taiwan
Tel: 886-6-289-1478 *Fax:* 886-6-289-1488

Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 *Fax:* 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
Tel: 82-51-643-5571 *Fax:* 82-51-643-5572

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong, Republic of China

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
Tel: 976-70006960 *e-mail:* rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29-00184 Roma, Italia
Tel & Fax : 39-06-48913949 *e-mail:* roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK

Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai of Paris

International Buddhist Congregation (IBC)

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Branches under the South Asia Division

Rissho Kosei-kai of Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar, New Delhi
110060, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya

Ambedkar Nagar, West Police Line Road
Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Rissho Kosei-kai of Patna

Rissho Kosei-kai of Singapore

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218 *e-mail:* info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh
Tel: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station: Mirshari,
District: Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Ramu

Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
Tel: 94-11-2982406 *Fax:* 94-11-2982405

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Other Groups

Rissho Kosei-kai Friends in Shanghai